

“Орон нутгийн санаачлага” ТББ

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НҮДЭЭР ТӨСӨВ

Мониторингийн тайлан



ОРОН НУТГИЙН
САНААЧЛАГА



ma
ma
cash

“ОРОН НУТГИЙН САНААЧЛАГА” ТББ

**Эмэгтэйчүүдийн нүдээр
ТӨСӨВ**

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Өвөрхангай аймаг

2008он

Энэхүү тайланг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл ОРОН НУТГИЙН САНААЧЛАГА ТББ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авах буюу иш татсан тохиолдолд байгууллага болон энэхүү тайлангийн нэрийг заавал дурдана.

Боловсруулсан : Ш.Бямбаа, Т.Чулуунцэцэг, О.Цэрэндулам
Хянасан : Ш.Бямбаа

Санал хүсэлт байвал доорх хаягаар холбоо барина уу?

ОРОН НУТГИЙН САНААЧЛАГА ТББ
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ, АРВАЙХЭЭР СУМ
АЙМГИЙН ЗДТГ- ЫН БАЙР 107 ТООТ ӨРӨӨ

УТАС/ФАКС : 01322-22667
E-майл хаяг: uvwsp@yahoo.com

ГАРЧИГ

ТАЛАРХАЛ

МОНИТОРИНГ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
МОНИТОРИНГ ХИЙХЭД АШИГЛАСАН ХОЛБОГДОХ ХУУЛИЙН
ЗААЛТУУД

МОНИТОРИНГИЙН ТАНИЛЦУУЛГА

- МОНИТОРИНГ ХИЙХ БОЛСОН ШАЛТГААН
- ТӨСЛИЙН НЭР
- ТӨСЛИЙН ҮНДСЭН ЗОРИЛГО
- ТӨСЛИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ
- ХАМАРСАН ХУГАЦАА, ХҮРЭЭ, БАЙРШИЛ
- МОНИТОРИНГИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН
- МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

МОНИТОРИНГИЙН ДҮН

ДҮГНЭЛТ БА САНАЛ, ЗӨВЛӨМЖ

НОМ ЗҮЙ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ

ТАЛАРХАЛ

Энэхүү тайланг бэлтгэж боловсруулахад туслалцаа үзүүлж хамтран ажилласан дараах байгууллага, хувь хүмүүст гүн талархал илэрхийлье.

- ◆ Мониторинг хийхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн “Монголын эмэгтэйчүүдийн сан”
- ◆ Өвөрхангай аймгийн Засаг Дарга Б.Эрдэнэбилэгт
- ◆ Өвөрхангай аймгийн НБЗХ-ийн Эрүүл мэндийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Я.Жаргал
- ◆ Өвөрхангай аймгийн МХГ-ын санхүүгийн хэлтсийн дарга Б.Болормаа
- ◆ Өвөрхангай аймгийн МХГ-ын санхүү хэлтсийн мэргэжилтэн С.Чулуунтогтох
- ◆ Өвөрхангай аймгийн Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төвийн дарга Р.Дуламсүрэн
- ◆ Өвөрхангай аймгийн Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төвийн ня-бо Г.Ганчимэг
- ◆ Арвайхээр сумын ЗДТГ-ын Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын ажил хариуцсан түшмэл Д.Уртнасан
- ◆ Эрүүл мэндийн яамны бодлого төлөвлөлт зохицуулалтын газрын дарга Ц. Бүжин

МОНИТОРИНГ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай байгууллага 1997 онд Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний салбар зөвлөл нэртэйгээр байгуулагдсан.

2007 оны 3-р сараас чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт хийж, орон нутагт төвтэй үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг “Орон нутгийн санаачлага” төрийн бус байгууллага болон бүртгүүлэн ажиллаж байна.

“Орон нутгийн санаачлага” ТББ нь нам бус, гишүүнчлэлгүй нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага. Орон тооны 4 ажилтантай, 10 жил тогтмол үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Байгууллагын эрхэм зорилго:

Хөдөөгийн хөгжилд нутгийн иргэдийн буюу иргэний нийгмийн шийдвэрлэгч оролцоог хангах явдал юм.

Зорилт:

- ◆ Орон нутгийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн асуудлаар төрийн бодлого, хууль тогтоомжинд нөлөөллөх
- ◆ Нутгийн засаг захиргааны бодлого, шийдвэр гаргах үйл явцад үзүүлэх иргэний оролцоо, хяналт, нөлөөллийг өргөжүүлэн хөгжүүлэх
- ◆ Сайн засаглалын тулгуур болсон нутгийн захиргаа, иргэний нийгэм, хувийн хэвшлийн 3 талт хамтын ажиллагааны түншлэлийг бэхжүүлэх
- ◆ Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг сайжруулахад туслах
- ◆ Нутгийн иргэдийн иргэний боловсролыг дээшлүүлэх
- ◆ Хөдөөгийн эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалахад туслах

Орон нутгийн санаачлага ТББ нь байгуулагдсан цагаасаа эхлэн 10 жилийн хугацаанд 40 гаруй төсөл хэрэгжүүлсэн.

Эдгээр төслийн 99 % нь орон нутагт жинхэнэ ардчиллыг төлөвшүүлэхэд чиглэгдэж ирсэн.


Монгол улсын төсвийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг анх удаа 1999 онд хийж хэрэгжүүлж эхэлсэн анхны байгууллага юм.

Төсвийн ил тод байдлыг хангах талаар хийсэн ажлаасаа дурдвал:

- Орон нутгийн болон үндэсний түвшин дэх төсвийн судалгааг 5 удаа хийж холбогдох байгууллагуудад хүргүүлж байсан.
- төсвийн талаарх мэдээлэл бүхий “Гурвалжин мэдээ” сонинг сар тутам нэг буюу нийт 46 дугаар гаргаж, олон нийтийн хүртээл болгосон.
- Төсвийн орлогын бүрдүүлэлтэд хүү торгуулийн эзлэх байрын талаар мониторинг УИХ-д тодорхой саналууд дэвшүүлж байсан.
- Хөдөөгийн сургуулийн дотуур байрны хүүхдүүдэд төсвөөс олгож байгаа мөнгөний үнэн зөв ашиглалтын талаар мониторинг хийж Боловсролын яаманд хүргүүлэн, улмаар энэ асуудлыг сайжруулах Засгийн газрын тогтоол гаргуулж байсан.
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хууль сумын түвшинд хэрхэн хэрэгжиж байгаа талаарх “Сумын төсөв” мониторингийн тайлан гаргаж, УИХ-ын гишүүдэд хүргүүлж байсан.

Сүүлийн 9 жил төсвийн үйл ажиллагааг ил тод, олон нийтийн хяналттай болгох чиглэлээр тогтмол ажиллаж, үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлж байна.

Орон нутгийн санаачлага ТББ нь төсвийн явц болон мэдээллийг ил тод, нээлттэй болгоход чиглэгдсэн өөрсдийнхөө үйл ажиллагааг дэмжихийг шаардсан саналыг Аймгийн Засаг дарга асан О. Батмөнхөөс эхлээд Сангийн сайд асан Ч.Улаан хүртэл илгээн нөлөөлж, зохих дэмжлэг хүлээж байв.



ЭРХЗҮЙН ОРЧИН.

Мониторинг хийхэд баримталсан хууль эрхзүйн заалтууд.

Хууль тогтоомжууд	Хуулийн зүйл заалтууд
Монгол улсын Үндсэн хууль	1-р зүйл 2 хэсэг, 26-р зүйл 3 хэсэг
Монгол улсын авилгын эсрэг хууль	5-р зүйл 1 хэсэг, 6-р зүйл
Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хууль	36,37,39,40,41,42,45-р зүйл
Төрийн албаны тухай хууль	4-р зүйл 2 хэсэг 2 заалт
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль	6-р зүйл
Яамны эрх зүйн байдлын тухай хууль	4-р зүйл 2 хэсэг
Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль	14-р зүйл 5 хэсэг
Монгол улсын Их Хурлын тухай хууль	31-р зүйл 1 хэсэг
Засгийн газрын тухай хууль Монгол Улсын Засгийн газрын тогтоол	8-р тогтоол
Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын тушаал	117-р тушаал
Монгол Улсын Сангийн сайдын тушаал	441-р тушаал
Аймгийн Засаг даргын 2004- 2008 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр.	2004 оны ИТХ-ын тогтоол

МОНИТОРИНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Мониторинг хийх болсон шалтгаан.

Эмэгтэйчүүд бид улсын эдийн засаг, өмч хөрөнгө, төсөв санхүүгийн асуудалд хяналт тавин оролцож түүнээс зохих үр ашиг хүртэх эрхтэй, Гэвч энэ нь амьдрал дээр тэр бүрий зөв сайн хэрэгждэггүй билээ.

“Олон улсын төсвийн төсөл” судалгааны байгууллагаас хөгжиж буй 36 оронд Төсвийн нээлттэй байдал ямар байдгийг судалсан байна. Тэрхүү судалгааны 2006 оны дүнгээс үзэхэд Монгол улс иргэддээ төсвийн мэдээлэл өгөх болон төсвийн тайлангийн мониторинг үнэлгээгээрээ “О” гэсэн үнэлгээ үзүүлэлттэй гарсан байна. Төсвийн мэдээллийн хаалттай байдал нь эмэгтэйчүүдийн нийгмийн баялагаас зүй ёсны хувь хүртэж, эрх ашгаа хамгаалан хангах бололцоог алдагдуулж буй нэгэн саад бэрхшээл юмаа.

Манай байгууллага төсвийн нээлттэй ил тод байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг сүүлийн 9 жил тогтмол явуулсан бөгөөд энэ үйл явцдаа орон нутгийн хүн амын үйлчилгээнд зориулан улсын төсвөөс олгож буй мөнгө хөрөнгийг үр дүн муутай зарцуулах, завших явдал олонтаа гарч байгааг арилгуулах арга хэмжээ авахуулж үр ашигтай саналууд дэвшүүлж ирсэн билээ. Энэ удаад бид Эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагуудын төсвийн зардалд хяналт судалгаа хийсэнээр эмнэлгийн орны цагаан хэрэглэл, эмч ажилчдын халтад, малгай г.м зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авахад зориулан улсын төсвөөс жил бүр хуваарилдаг хөрөнгө мөнгөөр орон нутгийн 35-55 насны эмэгтэйчүүдэд ажлын байр бий болгох, тэдний орлогыг байнга, тогтвортой нэмэгдүүлж байх нэгэн шинэ эх үүсвэр болгон, захиалагч, нийлүүлэгч 2-ын аль алинд нь илүү ойр, эдийн засгийн хувьд үр ашигтай зарцуулж болох юм гэдгийг мэдэж авсан юм.

Орон нутаг дахь зөөлөн эдлэл, нормын хувцасны зардал бол улсын хэмжээнд тендер зарлан шалгаруулахгүйгээр төсөвт байгууллага, аймаг өөрөө мэдэж бараа ажил үйлчилгээ худалдан авахыг хуулиар нэгэнт зөвшөөрсөн хэмжээнд бүрэн багтдагаас гадна түүнийг үйлдвэрлэхэд өндөр технологи шаардагдахгүй, ердийн үйлдвэрлэлийн мэргэжилтэй ажилчин хийж гүйцэтгэж болох ажил учраас орон нутагаа дэмжин хөгжүүлж, аймаг сумын 35-55 насны эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлж болох юм гэсэн саналыг бид дэвшүүлж байгаа бөгөөд ийм санал Монгол улсад урьд өмнө нь гарч байгаагүй тул онцлон анхаарч, зоригтой туршиж үзмээр байна.

Нөгөө талаас заавал 35-55 насны орлого багатай эмэгтэйчүүд гээд байгаагийн гол шалтгаан нь :

Өвөрхангай аймгийн 2007 оны статистик мэдээгээр ажилгүй гэж бүртгэгдсэн нийт хүмүүсийн 81%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Түүн дотроос 35-55 насны мэргэжил багатай эмэгтэйчүүдийн орлого, амьдралын байдал, ирээдүй бүрхэг байгаа талаар багуудын Нийтийн хурал, эмэгтэйчүүдийн янз бүрийн хурал, цуглаан, сонгуулийн үеийн уулзалт ярилцлагууд дээр их хурц яригдах боллоо. Дээрх насны эмэгтэйчүүд Өвөрхангай аймгийн нийт эмэгтэйчүүдийн 25%-ийг эзэлдэг. Тэдний амьдрал хүнд байгаагийн шалтгаан нь хуучин системийн үед ид залуу байж, улсын томоохон үйлдвэр, үйлчилгээний газар бага тушаалын ажил хийж байсан. Зах зээлд орсноор улсын үйлдвэрүүд олноороо хаагдаж, хамт олон, харъяалах албан газаргүй, өмч хөрөнгөгүй үлдсэн, одоо ажилгүй учир нас ахиж яваа боловч цагаа болохоор тэтгэвэр тэтгэмжгүй хоцрох хүмүүс юм. Тэд одоо нийгмийн амьдрал, үйлдвэрлэлээс хол хөндий учраа олж мэдэхгүй хүмүүс болоод байна.

Учир нь:

- ажлын зараар ажилд оръе гэхээр 35 наснаас дээш учир нас, бие заасан шалгуурт багтдаггүй
- тэтгэвэрт гарах нас болоогүй учир нийгмээс авах орлогогүй
- нэн ядууд багтдаггүй учир халамжаас тэтгэмж тусламж авах боломжгүй
- компьютер, англи хэл, багаар ажиллах гэх мэтийн орчин үеийн мэдлэг байхгүй учир албан тушаалын ажилд тэнцэхгүй,
- зээл авч бизнес хийе гэхээр барьцаалах хөрөнгөгүй
- зах зээлд өрсөлдөхүйц чанартай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх эх үүсвэргүй
- олигтой хувцас хунар байхгүйгээс гадагшаа гарч хүнтэй юм ярихаас ичдэг учир гэрээсээ гардаггүй

Гэвч 35-55 насны орлого багатай эмэгтэйчүүдэд өөрийн гэсэн давуу тал, нөөц байна. Тухайлбал

- ажил, амьдралын тодорхой туршлагатай, нас тогтсон
- амьдралынхаа төлөө зүтгэж ажиллах чин хүсэл эрмэлзэлтэй \ хүүхдүүд нь оюутан болох гэж байгаа, болчихсон учир мөнгө их хэрэгтэй\
- ажил шилж голдохгүй
- 80 гаруй хувь нь гэртээ оёдлын машинтай, оёдол эсгүүр хийх дадал олсон, зарим нь мэргэшлийн
- баг хамт олон болж, хамтран ажиллах хүсэл сонирхолтой
- ажиллах цагийн бүрэн боломжтой
- ар гэрийн татлаа бага, хүүхэд том болсон зэрэг болно.

Иймд эдгээр ид идэвхитэй хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийг нийгмийн ажил үйлчилгээнд оролцуулж, амьжиргааг нь дээшлүүлэхэд туслах хэрэгтэй байгаа билээ.

Мониторингийн зорилго

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах замаар орлого багатай 35- 55 насны орон нутгийн эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх , ажлын байр шинээр бий болгох боломж байгаа эсэхийг тодорхойлох зорилготой.

Мониторингийн зорилтууд

1. Өвөрхангай аймгийн Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төвийн төсвийн зарцуулалт дахь зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах төсвийн хэмжээ болон түүний ханган нийлүүлэлтийн талаарх бодит мэдээллийг олон нийтэд ил тод болгох
2. Төсвийн байгууллагуудын зөөлөн эдлэл нормын хувцасны ханган нийлүүлэлтийг орон нутгийн 35-55 насны эмэгтэйчүүд гүйцэтгэх бодит боломж, чадавхи байгаа эсэхийг болон энэ зорилтыг хэрэгжүүлэх эдийн засаг нийгэмшил, эрх зүйн орчинг тодорхойлох.

Мониторингийн хамрах хүрээ , байршил , хугацаа

Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд байрладаг Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төв . Энэхүү БОЭТ нь Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Дундговь, Өмнөговь, Булган, Говь-Алтай 7 аймгийг хамран оношлох, эмчлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүсийн эмнэлэгийн байгууллага юм.

Арвайхээр сумын 9 багийн хувиараа оёдлын үйлдвэрлэл эрхэлж, гэрээр оёдол хийдэг 35-55 насны 80 гаруй иргэн болон Бумбат, Талст, Эмт, Андууд, Ноён-Хайрхан, Шилмэл загвар зэрэг 8 оёдлын цехийн оёдолчид хамрагдав.

Мониторинг хийсэн хугацаа: 2007 оны 12-р сараас 2008 оны 7-р сар

Мониторинг хийсэн баг

Овог нэр	Албан тушаал	Байгууллага
1. Ш.Бямбаа	Гүйцэтгэх захирал	Орон нутгийн санаачлага ТББ
2. Т.Чулуунцэцэг	Санхүүгийн менежер	Орон нутгийн санаачлага ТББ
3. О.Цэрэндулам	Олон нийттэй харилцах менежер	Орон нутгийн санаачлага ТББ
4.Б.Болормаа	НХХХ-ын улсын ахлах байцаагч	Өвөрхангай аймгийн МХГ
5. С.Чулуунтогтох	Санхүүгийн улсын байцаагч	Өвөрхангай аймгийн МХГ

Мониторингийн арга зүй, аргачлал



- ◆ Баримт бичиг дүн шинжилгээ хийх
- ◆ Кэйс судлал
- ◆ Ганцаарчилсан ярилцлага
- ◆ Бүлгийн ярилцлага
- ◆ Анкетын арга

Баримт бичигт дүн шинжилгээ хийх арга

БОЭТ-ийн 2006, 2007 оны санхүүгийн тайлан, баримт бичгээс зөөлөн эдлэл, нормын хувцасны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн байдалд анализ дүгнэлт хийсэн. Мөн аймгийн Төрийн сан, Эрүүл мэндийн газраас аймгийн төсөвт байгууллагуудын энэ талаарх бүх мэдээллийг авч нэгтгэн дүгнэсэн.

Кэйс судалгааны арга

Мониторингийн явцад үүсч гарсан асуудлуудыг тухайн холбогдох газруудаас лавлан, урьд гарч байсан кэйсүүдтэй жишиж судласан. Жишээ нь : БОЭТ өөрсдөө тасгаараа халад хийж байсан, Өвөрхангай аймагт ажиллаж байсан гадаадын хөрөнгө оруулалттай оёдлын үйлдвэр, Улаанбаатар хот дахь Их-Уул ХХК, БОЭТ-ийн угаалгын газар зэрэгт ийнхүү судлав.

Ганцаарчилсан ярилцлага

20 гаруй холбогдох төрийн албан хаагч, 8 оёдлын цехийн 10 гаруй оёдолчин, гэрээрээ оёдол хийдэг 60 гаруй иргэнтэй ярилцлага хийж дүгнэлт гаргав.

Бүлгийн ярилцлага

Эмнэлгийн 2-3 тасгийн эмч , ажилтнуудад зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн талаарх баримт мэдээллийг танилцуулж түүний ил тод байдлын талаар фокус ярилцлагууд хийсэн.

Анкетийн арга

Арвайхээр сумын 9-н багийн оёдол хийдэг 35-55 насны 110 гаруй хүмүүсийг түүвэрлэн авч оёдол эрхэлж орлого олох, нэмэгдүүлэх сонирхолтой эсэх, зөөлөн эдлэл нормын хувцсанд зориулж орж ирдэг төсөв мөнгөний талаар мэдлэг мэдээлэлтэй эсэхийг анкетын аргаар тандаж үзэв.

МОНИТОРИНГИЙН ДҮН


Өвөрхангай аймаг дахь төсөвт байгууллагуудын улсын тендер зарлахгүйгээр зөөлөн эдлэл нормын хувцас худалдан авахад зориулагдсан төсвийн хөрөнгийг орон нутгийн жижиг үйлдвэр байгуулаж, 35-55 насны эмэгтэйчүүдийг ажлаар хангаж, орлогыг нь тогтмол нэмэгдүүлэн, чанартай бүтээгдхүүн үйлдвэрлэх эх үүсвэр болгон ажиллах боломж байна.

1.Өвөрхангай аймгийн хэмжээнд бидний хийсэн мониторингид хамрагдсан бүх төсөвт байгууллагын зөөлөн эдлэл нормын хувцсанд нийлбэр дүнгээрээ жил бүр дунджаар 55-60 сая төгрөгийн төсөв батлагддаг байна.

Өвөрхангай аймгийн 2006, 2007 оны төсөв дэх зөөлөн эдлэл нормын хувцасны төлөвлөгөө, гүйцэтгэлийг үзүүлбэл:

Хүснэгт №1

	2006 он /мян.төг/		2007 он /мян.төг/	
	төлөвлөлт	гүйцэтгэл	төлөвлөлт	гүйцэтгэл
Улсын төсөв	53,098.0	34,768.0	57,484.0	59,660.0
Орон нутгийн төсөв	2,106.0	1,644.3	3,691.4	3,591.6
Нийт төсөв	55,204.0	36,432.3	61,175.4	63,251.6



**Өвөрхангай аймгийн төсвийн бүх байгууллагуудын
2006, 2007 оны төсөв дэх зөөлөн эдлэл нормын хувцасны
төлөвлөгөө , гүйцэтгэл**

Хүснэгт №2 / мян.төг /

Төсвийн байгууллагууд	2006		2007	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Статистикийн хэлтэс	0.0	0.0	0.0	0.0
Байгаль орчны алба	300,0	300,0	344,5	344,5
УЦУОШТөв	200,0	200,0	300,0	300,0
Боловсрол Соёлын газар	0.0	0.0	0.00	0.00
Ерөнхий боловсролын сургууль	19,430,5	7,445,3	20,116.4	20,086.0
Орон нутгийн музей	300,0	484,8	300,0	300,0
Орон нутгийн номын сан	80,0	80,0	80,0	80,0
Соёлын төв	190,0	366,25	1,800.0	1,891.7
Хөгжимт драмын театр	500,0	500,0	900,0	123,5
Хүүхдийн цэцэрлэг	6,535,1	6,175,4	5,985.7	8,599.5
Ясли	157,5	0.0	200,0	200,0
Стандарт хэмжил зүйн төв	120,0	120,0	200,0	200,0
Хүүхдийн байгууллага	0.0	0.0	0.00	0.00
Мэргэжлийн Хяналтын Газар	0.0	0.0	0.00	0.00
Ахмадын хороо	0.0	0.0	0.00	0.00
Хөдөлмөр халамжийн хэлтэс	130,0	130,0	130,0	130,0
Онцгой байдлын хэлтэс	250,0	682,0	275,0	163,8
Хөдөө аж ахуйн газар	100,0	100,0	100,0	100,0
Цагдаагийн хэлтэс	0.0	0.0	0.0	0.0
Өрхийн эмнэлэг	0.0	0.0	0.0	0.0
БГГХӨТТөв	623,3	620,6	623.3	618.1
Биеийн тамир, спортын хороо	25,0	18.3	50,0	50,0
Нэгдсэн эмнэлэг	11,717,5	6,677,4	8,000.0	8,000.0
Рашаан сувилал	0.0	0.0	5,650.0	5,650.0
Хүн эмнэлэг	12,386,1	10,814,6	12,386.1	12,710.9
Эрүүл мэндийн газар	53,0	53,0	53,0	53,0
Орон нутгийн төсөв	2,106,0	1,664,3	3,691.5	3,591.5
Нийт дүн	55,204,0	36,432,3	61,175.4	63,252.3

2. Өвөрхангай аймгийн Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төвийн зөөлөн эдлэл нормын хувцасны зардалд жил бүр 8-11 сая төгрөг орж ирдэг байна.

2006, 2007 оны БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэл

Хүснэгт №3

Тайлант онууд	төсвийн төсөл	батлагдсан төсөв	төсвийн гүйцэтгэл	
			тайлангаар	баримтаар
2006	9,343.5	11,717.5	6,677.4	6,228.6
2007	13,007.5	8,000.0	8,000.0	8,385.14

3. Төсөвт байгууллагуудаас гадна Дэлхийн Зөн Олон Улсын байгууллага, Тогтвортой Амьжиргаа төсөл гэх мэт Олон улсын төслийн байгууллагууд орон нутгийн сургууль, эмнэлэг, цэцэрлэг зэрэг төсөвт байгууллагуудад зөөлөн эдлэл нормын хувцсанд бас санхүүжилт олгодог байна.

Жишээ нь: Дэлхий Зөн ОлонУлсын байгууллага 2006 онд 5.0 сая гаруй төгрөг, 2007 онд 1,8 сая төгрөгийг, Тогтвортой Амьжиргаа төслөөс жил бүр тодорхой хэмжээний мөнгийг зөөлөн эдлэл нормын хувцсыг худалдан авахад нь зориулан санхүүжүүлжээ.

4. Сүүлийн үед банк, үүрэн телефоны болон худалдаа үйлчилгээний компани гэх мэт бизнесийн байгууллагууд байгууллагынхаа имиджийг бүрдүүлж, ажилчдаа жигд хувцаслалтаар хангах зорилгоор зохих хөрөнгө мөнгө гарган ажлын дүрэмт хувцаснуудыг олноор нь захиалж хийлгэдэг болжээ.

Дээрх байдлаас зөөлөн эдлэл нормын хувцасны чиглэлээр дагнан ажиллаж ашиг олох хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийн нөөц орон нутагт байна гэж үзэж болохоор байна .

Гэтэл энэхүү санхүүгийн баталгаатай нөөц орон нутагтаа шингэж, нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр болж чадахгүй байна .
Учир шалтгаан юу вэ гэвэл:

1. Орон нутгийн төсөвт байгууллагуудад энэ зориулалтаар хуваарилагдаж буй хөрөнгө нь хэмжээгээрээ улсын хэмжээний тендер шаарддаггүйн дээр тухайн байгууллагуудад энэ асуудлыг дотооддоо зохицуулсан дүрэм журам байдаггүйгээс худалдан авах үйл ажиллагаа зөвхөн байгууллагын дарга, ня-богийн үзэмж, ашиг сонирхлоор далд хаалттай явагдаж ирсэн гаж зуршил үргэлжилж байна.

2. Төсвийн зөөлөн эдлэл нормын хувцасны хангалтад зориулагдсан төсвийн талаарх мэдээлэл хаалттай учраас оёдол эсгүүрийн бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд оролцох эрх зүйн таатай орчин бүрдээгүйгээс хөдөө орон нутагт зөөлөн эдлэл нормын хувцасны дагнасан үйлдвэр өнөөг хүртэл хөгжөөгүй байна.

3. Орон нутагт өөрийн гэсэн бие даасан оёдлын үйлдвэр байхгүй учраас аймгийн төсөвт байгууллагууд Улаанбаатар хотын компаниудыг алсыг харж, алгаа тосож бэлэнчилж суудаг.

Жишээ нь: Зөвхөн тус аймгийн БОЭТ-ийн 2006, 2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны 85-90% -ийг Улаанбаатар хотын компаниудаас нийлүүлснийг доорх хүснэгт графикаас харж болно. Аймгийн бусад төсөвт байгууллагууд ч мөн адил зөөлөн эдлэл нормын хувцасны ихэнхийг Улаанбаатар хотоос нийлүүлдэг байна. Үүнийг дараахь хэдэн баримтаар нотолж болно.

**БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны
2006-2007 оны нийлүүлэлтийн байдлыг үзүүлье**

А-2006 он

Хүснэгт 4

Нийлүүлсэн аж ахуй, хүмүүс	Нийлүүлсэн зөөлөн эдлэл нормын хувцасны төрөл	Хаанаас нийлүүлдэг	Мөнгөн дүн /мян.төг/		Дүн / % /
Их-Уул ХХК	Халад, өмд цамц, хагалгааны бүтээлэг	Улаанбаатар	5.671,2	5.796,6	92.7
Дөл ХХК	Нярайн даавуу		98.4		
Дөрвөн-Марал ХХК	Нярайн даавуу	Өвөрхангай	70,0	459,0	7.3
Цэцэн харцага ХХК	Эмчийн халад		11,0		
Баяннайман ХХК	Хүүхдийн хөнжил		40,0		
Насантогтох	Мэс заслын даавуу		338,0		
Нийт дүн			6.228,6		100

Б-2007 он

Хүснэгт 5

Нийлүүлсэн аж ахуй, хүмүүс	Нийлүүлсэн зөөлөн эдлэл нормын хувцасны төрөл	Хаанаас нийлүүлдэг	Мөнгөн дүн /мян.төг/		Дүн / % /
Их-Уул ХХК	Халад, өмд цамц, ор хөнжлийн даавуу, хормогч	Улаанбаатар	5.195,85	7.095,8	84.6
Ширээт заан ХХК	Ор хөнжлийн даавуу, гудас, хөнжил		1.900,0		
Арцат Богд Трейд ХХК	Хагалгааны даавуу	Өвөрхангай	880,0	1.289,2	15.4
Дэгддулам	Тахлын хувцас		300,0		
Насантогтох	Мэс заслын даавуу, бүтээлэг		109,29		
Нийт дүн			8.385,14		100

Дээрх хоёр жилийн зөөлөн эдлэл нормын хувцасны нийлүүлэлтэд хот хөдөөгийн эзлэх хувийг харьцуулвал

График №1





График №2



Орны даавуу, эмнэлэгийн болон ахуйн хэрэглээний хормогч мэтийг нийслэлд үйлдвэрлэж, орон нутагт зөөвөрлөн тээвэр, холбооны илүүц зардал гаргах хэрэг юу байна гэдгийг энэ тоо “асууж” байна.

Улаанбаатар хотоос аймагт зөөлөн эдлэл нормын хувцсыг бэлтгэн нийлүүлэхэд дараах дутагдалтай талууд байна.

- холоос тээвэрлэж байгаа учраас дагалдах тээвэр , холбооны болон захиргааны зардлууд нэмэгдэж , барааны өөрийн өртөг , үнэ өсдөг
- Захиалга дотор таарч тохирохгүй хувцас ирдэг учраас хасуулах зэрэг дахин засвар хийлгэх болж нэмэлт зардал гардаг.
- Нийлүүлэгч, захиалгач нар хол учир хяналтгүй үйлдвэрлэж, хариуцлага тооцох боломжгүй буюу хүндрэлтэй .
- Орон нутагт жижиг бизнесийг өргөжүүлж төвлөрлийг сааруулахад саад учруулдаг.
- Захиалагч, нийлүүлэгчийн ажиллагаа үнэн хэрэгтээ олон нийтэд хаалттай, нэг үгээр хэлвэл өөрт ноогдсон хөрөнгийг өөрөө мэдэж үр ашигтай зарцуулж чадахгүй байна.

2. Орон нутгийн төсвийн байгууллагуудын зөөлөн эдлэл нормын хувцасны зориулалт, хэрэгцээт төсвийн эх үүсвэрийг ашиглан үйлдэрлэл явуулж ханган нийлүүлэх үйлдвэрлэлийн хүчин чадал, орон нутгийн дараахь нөөц байна. Үүнд:

А. Хөдөлмөрийн багаж хэрэгсэл, ажиллах хүч буюу хүний нөөц хангалттай байна.

- Өвөрхангай аймгийн төв Арвайхээр сумын нийт өрхийн 80 гаруй хувь нь оёдлын машинтай бөгөөд өрхийн хэрэгцээнийхээ хувцсыг өөрсдөө оёж , өдөр тутмын хэрэгцээнийхээ 40 гаруй хувийг гэрийн үйлдвэрлэлээр хангадаг. Энэ судалгаа Арвайхээр хотын захиргааны байгууллагад бэлэн байгаа болно.
- Оёдол эрхэлж байсан олон ажилгүй эмэгтэйчүүдээс гадна Өвөрхангай аймгийн төв дэхь Технологийн их сургуулийн харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд оёдлын анги хичээллэдэг.Түүнд 30 цахилгаан оёдлын машин суурилуулсан энэ сургалтын орчинд оюутан суралцаж , дадлага хийж, жил бүр 30 гаруй хүүхэд оёдолчины мэргэжил эзэмшин гарч байгаа боловч ажлын байр олддоггүй.

Б. Үйлдвэрлэл үүсгэн явуулахад мэргэжсэн энгийн анхны суурь бүтцүүд байна.

Өмч хувьчлалаас өмнөх Нийтийн ахуйн үйлчилгээний газар орон нутгийнхаа ажлын болон нормын хувцасыг үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангадаг байсан уламжлал бий. Өмч хувьчлалаас хойш тэнд ажиллаж байсан өндөр ур чадвартай оёдолчин, эсгүүрчин, мастер, технологич хүмүүс өнөөдөр өөрийн гэсэн оёдлын цэгтэй түүнийгээ өргөтгөх хүсэлтэй ажилладаг байна. Арвайхээр суманд л гэхэд оёдлын 8 цех байна. Гагцхүү тэдэнд санхүүгийн эх үүсвэр, дэмжлэг, мэдээлэл алга.


Орон нутгийн зөөлөн эдлэл нормын хувцасны
ханган нийлүүлэх үйлдвэрлэлийн хүчин чадлын нөөц

Хүснэгт №6

Нэрс	Нас	Мэргэжил	Ажлын туршлага	Тоног төхөөрөмж	Ажлын байрны стандарт	Бусад
И.Алтан-цэцэг	45	Оёдол эсгүүрийн технологич	Унгар улсад 10гаруй жил - тогооч -цэцэрлэгийн багш - эмнэлгийн мэргэжилтний хувцас оёдог байсан одоо өөрийн оёдлын цехтэй	Төрөл бүрийн 5 машинтай	Түрээсийн байранд одоо байраа томсгох гэж байгаа	2ажилчинт ай Нэмж 2 оёдолчин авна.
Ц.Гүнсм аа	53	Эсгүүрчин	Нийтийн ахуй үйлчилгээний захиалгын албанд ажилладаг байсан. Өөрийн оёдлын цехтэй	380 вольтын хүчин чадалтай 2 машинтай бусад техник байгаа	4 хүний ажиллах өөрийн байртай	Туслах оёдолчинт ой
М.Намжил-сүрэн	37	Оёдолчин	Нийтийн ахуй үйлчилгээний оёдолчин байсан, өөрийн оёдлын цехтэй	Цахилгаан машин хэрээсний товчны машин тус бүр 2 машинтай	Түрээсний байранд	2 хүн ажилладаг
Б.Бат-дулам	43	Оёдолчин	Ээрмэлийн үйлдвэрт тооцоо гаргагч, оёдлын үйлдвэрт оёдолчин, Дэлгэрэх оёдлын үйлдвэрт мастер, Арвайхээр хувцас захиалгад оёдолчин оёдлын цехтэй	2 цахиалгаан машинтай, хэрээсний болон товчны машинтай	Түрээсний байранд	
Ганчимэг	41	Оёдолчин	Нийтийн ахуй үйлчилгээнд захиалгын хувцасны бригад 1994 оноос хувиараа оёдол хийсэн.	Цахилгаантай байсан		Туслах оёдолчинт-той
Гэрэлмаа	38	Зохион бүтээгч	ТББ-д оёдлын багш,Ахуй үйлчилгээнд оёдолчин, өөрийн оёдлын цехтэй	Цахилгаан машинтай	Түрээсийн байранд	Туслах оёдолчинт-той
Даариймаа	38	Оёдолчин	Оросын Фрунзид оёдлын ТМС төгссөн Ахуй үйлчилгээнд захиалгат хувцасны тасагт ажиллаж байсан	Цахилгаан машинтай	Түрээсний байранд	Туслах оёдолчинт ой
		Оёдолчин	өөрийн оёдлын цехтэй	4 төрлийн	Түрээсний	3 туслах

Дээрх хүснэгтээс харахад хүний нөөц, тоног төхөөрөмж хангалттай байгаа боловч энэ чиглэлийн жижиг үйлдвэрлэлийг эмэгтэйчүүд хувиараа эрхэлдэг бөгөөд тэдний орлого өчүүхэн цаашилбал зах зээлийнх нь багтаамжийг хотынхон эзэлсэн учраас бие даасан хуулийн этгээдийн хэмжээнд ажлын байртай болж үйл ажиллагаагаа өргөтгөн явуулж чаддаггүй, мөн чанар сайтай зөөлөн эдлэл нормын хувцас хийх захиалга материалын сонголт хязгаарлагдмал гэх зэрэг хүндрэлтэй талууд байна.

Хэрэв төсвийн байгууллагын зөөлөн эдлэл нормын хувцсыг орон нутагтаа үйлдвэрлэн нийлүүлэх санхүүгийн эрх мэдэл олгож өгвөл нутгийн засаг захиргаа жижиг бизнесийг хөгжүүлж эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх, зах зээлийн багтаамж нь өргөсөж дээр дурьдсан хүндрэл бэрхшээлийг даван туулах бүрэн бололцоотой.



Би оёдол эсгүүрийн технологич мэргэжилтэй, Унгарт 10 гаруй жил оёдол хийсэн. Тэнд тогооч нар, эмнэлгийн ажилтны хувцас эсгэдэг байсан. Унгараас ирээд л шууд оёдлын цех цехээ ажиллуулсан. Одоо 3 дахь жилээ ажиллаж байна. Удахгүй шинэ стандартын ажлын байранд орж, ажилчидаа нэмнэ. Зөөлөн эдлэл нормын хувцасны ийм их мөнгө байдаг гэдгийг би мэдэхгүй. Хэрэв орон нутгийн оёдлын цехийг тендерт оруулбал би оролцож, оёдлын цехээ өргөтгөн 2 ээлжийн болгон 12 эмэгтэй ажиллуулж чадна гэж үзэж байна. Улаанбаатар хотын Их-Уул трейд компани ажлын хувцасыг их муу материалаар хийдэг юм билээ. Би бол эрүүл мэндийг сайн хангасан стандартын дагуу материалаар хийнэ.


Бумбат үйлчилгээний төв дэхь
Оёдлын цехийн захирал Алтанцэцэг

В Орон нутгийн эмэгтэйчүүдийн оёдлын үйлдвэрлэлийг дэмжсэн төрийн болон ТББ-ын дэмжлэг их чухал байна

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээр зохих оёдол эсгүүрийн түр сургалтанд хамруулах буюу шууд “элсүүлэх” замаар ажлын байр гарган өгч болно

Мөн Дэлхийн Зөн Олон Улсын Байгууллагын дэргэдэх Ноён-Хайрхан ТББ нь нэн ядуу эмэгтэйчүүдэд үнэ төлбөргүй оёдлын сургалтыг 2003 оноос хойш тогтмол явуулж байгаа бөгөөд нийт 70 ядуу эмэгтэйчүүд хамрагдан шулуун оёдол хийх чадвартай болсон байна

Захиалагч, хэрэглэгч талын удирдлагууд орон нутагт ийм төрлийн захиалгыг нийлүүлэгч гарч ирэхийг дэмжиж, энэ талаар орон нутгийн хөгжлийн бодлого чиглэлдээ тусгасан байна.



Зөөлөн эдлэл, ажлын хувцсаа орон нутгаасаа нийлүүлдэг үйлдвэртэй болчихвол манай эмнэлэг тэндээс захиалахыг л бодно. Хамгийн наад зах нь гэхэд гайгүй хийдэг компани эрж хайх, утсаар ярих, тээвэрлэн авчрах, гэрээгээ хийхээр явах томилолтын зардал гээд нэмэлт зардлууд гардаг. Эдгээр зардлууд хэмнэгдэнэ.

БОЭТ-ийн ерөнхий ня-бо Г.Ганчимэг

Орон нутаг дахь төсөвт байгууллагуудын зөөлөн эдлэл нормын хувцасыг хэрэглэх газар дээр нь үйлдвэрлэн нийлүүлдэг болох нь олон зүйлийн ач холбогдолтой юм. Тухайлбал:

- Хувцас хэрэглэгч байгууллагын ажилтнууд материалын сонголт хийж, биеийн галбир хэмжээндээ тааруулан захиалах боломжтой
- Захиалагч, хэрэглэгч бэлтгэн нийлүүлэгч нэгэн дор орших болсоноор захиалга өгөх тохиролцох хянах, бараа тээвэрлэхээс эхлээд гарах зардлууд хэмнэгдэж, бүтээгдхүүний өөрийн өртөг, үнэ хямдарна.
- Захиалагч, нийлүүлэгч харилцан хяналт тавьж нөлөөлөх, хариуцлагын тогтолцоо сайжран, болзошгүй авилгаас урьдчилан сэргийлнэ.
- Орон нутагт бизнес хөгжүүлж, ажилгүй байгаа мэргэжил чадвартай эмэгтэйчүүдийг ажлын байраар ханган, оёдлын цехтэй эмэгтэйчүүдийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.
- Холбогдох төсвийн ил тод байдлыг ханган, төсөвт оёдолчин эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж түүний үр нөлөөг сайжирна.
- Улаанбаатарт үйлдвэрлэж, хөдөөд нийлүүлэх худалдах худалдан авах ажиллагаа ил тод бус нууцлаг байгаагаас төсөв зардал завшигдаж болзошгүй байдлыг өөрчилнэ.
- Эмнэлгийн зөөлөн эдлэлийг хугацаанд нь нийлүүлэхээс гадна сургууль, цэцэрлэг, хувийн компаниуд, хөрш зэргэлдээ аймгуудын зөөлөн эдлэлийн захиалгыг авч энэ чиглэлээр дагнан мэргэшиж, ажилчдаа өөрсдөө бэлтгэн гаргадаг, өөрийн гэсэн хаяг шошго бүхий бренд бүтээгдэхүүнтэй эмэгтэйчүүдийн жижиг үйлдвэрийг орон нутагт үүсгэн бий болгох зэрэг олон сайн талын ач холбогдолтой билээ.

САНАЛ ЗӨВЛӨМЖ, ДУГНЭЛТ





ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Энэхүү мониторингийг аймаг дундын эрүүл мэндийн болон бусад төсөвт байгууллагын холбогдох төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тухайн ажил үйлчилгээний бодит байдлыг бүхэлд нь тодорхойлон харуулах өргөн хэмжээнд хийгдсэн гэж үзнэ. Түүний үр дүнд “Орон нутгийн төсөвт байгууллагын зөөлөн эдлэл цагаан хэрэглэл, нормын хувцасны зардлын төсвийн эх үүсвэрийг орон нутгийн жижиг үйлдвэр байгуулж, эмэгтэйчүүдийн зохих хэсгийг байнгын ажил, тогтмол орлогын эх үүсвэртэй болгож, уул бараа үйлчилгээний чанарыг дээшлүүлэн, захиалагч-нийлүүлэгчийг ойртуулж, хяналтыг сайжруулах боломжтой гэсэн дүгнэлт хийж, дараахь санал дэвшүүлж байна. Үүнд:

1.Улсад зарлагддаг тендерт хамаарагддаггүй төсвийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах үйл явцыг зохицуулах журмыг төсөвт байгууллага бүр дотооддоо боловсруулан дараахь асуудлуудыг тусган зохицуулах шаардлагатай байна.

- Худалдан авалтын ил тод байдлыг хангах.
- Ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох, дотоод тендерийн баримт бичиг боловсруулах, зарлан мэдээлэх, уг тендерийг комисс байгуулж нээх, үнэлэх, шалгаруулах, гэрээ байгуулах эрх олгох гэх мэт үе шат бүрд эмэгтэйчүүдийн оролцоог хангах
- Зөөлөн эдлэл, нормын хувцасны төсвийн төслийг боловсруулахдаа стандарт үнэлгээг үндэслэн байгууллагынхаа хамт олны оролцоотойгоор бодиттой шударга өрсөлдөөнийг дэмжиж хандах
- Бараа ажил үйлчилгээг чанартай нийлүүлэх талаар орон нутагтаа тогтмол үйл ажиллагаа явуулдаг гүйцэтгэгчийг тэргүүн ээлжинд сонгон, найдвартай нийлүүлэгчид болгох талаас нь дэмжсэн бодлого баримтлах
- Бараа үйлчилгээ захиалах, худалдаж авахтай холбогдон гарсан гажуудал үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх

Энэ журмыг боловсруулахад Орон нутгийн санаачлага ТББ мэргэжил арга зүйн талаар дэмжин туслах сонирхолтой байна.

2.Өвөрхангай аймагт Эмэгтэйчүүдийн зөөлөн эдлэлийн үйлдвэр байгуулах

- Энэхүү үйлдвэрийг ажлын хувцасны мэргэшсэн мэргэжлийн хүний удирдлага дор ажилгүй 35-55 насны эмэгтэйчүүдийг хамруулан 16-24 хүний бүрэлдхүүнтэй 2 ээлжийн ажилтантай, хувийн болон орон нутгийн өмчийн хувь нийлүүлсэн холимог компани ХК юмуу нөхөрлөл хоршооны хэлбэрээр үүсгэн байгуулж, эхний жилүүдэд зориулалтын төсвөөр нэмэлт санхүүжилт олгож, туршилтын журмаар ажиллуулах. Үүнийг Монголын Эмэгтэйчүүдийн сан , Орон нутгийн санаачлага ТББ нөлөөллийн үйл ажиллагаа явуулах замаар аймгийн ИТХ-д оруулан шийдвэрлүүлэх.
- Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг гэрээгээр мэргэжлийн байгууллагаар боловсруулан бэлэн болгох.
- Оёдолчин эмэгтэйчүүдэд стандартын дагуу зөөлөн эдлэл, нормын хувцас нийлүүлэх стандартын талаар нэмэлт сургалт явуулах хэрэгтэй байна. Энэхүү сургалтыг орон нутаг дахь Иргэний нийгмийн байгууллагууд хариуцан гүйцэтгэх боломжтой. (Өвөрхангай аймагт байнга үйл ажиллагаа явуулдаг 10 гаруй ТББ-ууд байдаг.)

Энэхүү бодит нөөц боломжийг орон нутгаа, эмэгтэйчүүдээ гэсэн чин сэтгэлээр овсгоо гарган үр дүнтэй бүрэн ашиглахгүй юм бол эмэгтэйчүүдийг дэмжинэ, орон нутагт жижиг бизнес хөгжүүлэхэд туслана гэж юу байх билээ.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ. 1992 он
2. Монгол Улсын Авилгын эсрэг хууль , УБ.2006
3. Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Төрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох нь , Бодлогын судалгааны цуврал, О.Мөнхбат, УБ. 2006
8. Мэргэжлийн боловсрол-Сайн бизнес, Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага, УБ, 2000
9. Боловсрол дахь жендерийн ойлголт, судалгаа, ЮНЕСКО, Бангкок, 2005
10. Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөний хэрэгжүүлэх хүрээ 2006-2010, УБ.2007
11. Эрүүл мэндийн яамны сайдын тушаал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МОНЭС	- Монголын эмэгтэйчүүдийн сан
ЗДТГ	- Засаг даргын тамгын газар
ТББ	-Төрийн бус байгууллага
НБЗХ	-Нийгмийн бодлого зохицуулалтын хэлтэс
МХГ	-Мэргэжлийн Хяналтын Газар
БОЭТ	-Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төв
ЭМЯ	- Эрүүл мэндийн яам

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ


1. График

- График №1** БОЭТ-ийн 2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны нийлүүлэлт
- График №2** БОЭТ-ийн 2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны нийлүүлэлт

2. Хүснэгт

- Хүснэгт №1** Өвөрхангай аймгийн 2006, 2007 оны төсөв дэх зөөлөн эдлэл нормын хувцасны төлөвлөгөө болон гүйцэтгэл
- Хүснэгт №2** Өвөрхангай аймгийн бүх төсвийн байгууллагуудын 2006, 2007 оны төсөв дэх зөөлөн эдлэл нормын хувцасны төлөвлөгөө болон гүйцэтгэл
- Хүснэгт №3** 2006, 2007 оны БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэл
- Хүснэгт №4** БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны 2006 оны нийлүүлэлтийн байдал
- Хүснэгт №5** БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны 2007 оны нийлүүлэлтийн байдал
- Хүснэгт №6** Орон нутгийн зөөлөн эдлэл нормын хувцасыг ханган нийлүүлэх үйлдвэрлэлийн хүчин чадлын нөөц

ХАВСРАЛТ ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ

ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ НОРМЫН ХУВЦАСНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН БАЙДАЛ

Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төвийн 2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсөвт хийсэн мониторингийн дүнг доор танилцуулж байна.

Төсвийн байгууллагын зардлын зүйл ангиудаас зөвхөн нэг зүйл ангийн зардлын төсөвлөлт, зарцуулалтыг харахад аливаа зардлыг норм норматив, стандарт дээрээ үндэслэн үйл ажиллагаатайгаа холбож бодитой төсөв мөнгөө төлөвлөдөггүй, энэ нь эргээд төсөв мөнгө хүрдэггүйн нэг шалтгаан болж байна.

Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төв 2006 онд 9343500 төгрөгний төсөв зөөлөн эдлэл нормын хувцсанд хэрэгтэй гэж төлөвлөж өгсөн байна. Эмч ажилчдын халад, ажлын хувцас болон эмнэлгийн цагаан хэрэглэлийн 1 ээлжийг шинэчилнэ, мөн хөнжил, гудсыг солино гэж доорх байдлаар төсөвлөсөн байна.

2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийг төсөвлөсөн нь:

Зардлын ангилал	2005 оны ХБГ	2006 оны төлөвлөгөө	2007 оны төлөвлөгөө	2008 оны төлөвлөгөө
Нийт ажиллагсад	230	253	253	253
1 ажлын хувцасны үнэ	16 000	17 000	19 000	21 000
Нийт ажлын хувцасны үнэ	3 680 000	4 301 000	4 807 000	5 313 000
Орны тоо	200	215	215	215
Цагаан хэрэглэлийн нэг бүрийн үнэ	8000	9500	9500	9500
Нийт цагаан хэрэглэлийн үнэ	1600000	2042500	2042500	2042500
Хөнжил гудас	3 000 000	3 000 000	3 000 000	3 000 000
Зөөлөн эдлэл авах зардал	8 280 000	9 343 500	9 849 500	10 355 500

2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв нь:

Зардлын ангилал	Батлагдсан төсөв
Зөөлөн эдлэл нормын хувцасны төсөв	11 717 500

Тайлбар: Гэтэл зөөлөн эдлэл нормын хувцсанд 11717500 төгрөгний төсөв батлагдаж ирсэн байна.

2006 оны БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн төсөл ба батлагдсан төсвийн харьцуулалт

2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн төсөл	2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв	Төсвийн төсөл болон батлагдсан төсвийн зөрүү	
		Тоогоор	Хувиар
9 343 500	11 717 500	2 374 000	25%илүү

Тайлбар: 2374000 төгрөгний төсөв БОЭТ-ийн өөрсдийн төлөвлөснөөс илүү батлагдаж ирсэн байна.

Зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэл

Зардлын зүйл анги	Төсвийн гүйцэтгэл /тайлангаар/
Зөөлөн эдлэл нормын хувцас	6 677 425

Тайлбар: 2006 оны санхүүгийн тайлангаас харахад 6677425төгрөг л зөөлөн эдлэл нормын хувцсыг авахад зарцуулагдсан байна.

2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт

2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв	2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэлийн зөрүү	
		Тоогоор	Хувиар
11 717 500	6 677 425	5 040 075	56.9%

Тайлбар:Зөөлөн эдлэл нормын хувцасны орж ирсэн төсөв нь 5 сая гаруй төгрөгөөр илүү гарсан байна.

Тайлан дээрх гүйцэтгэл болон баримт дээрх гүйцэтгэл:

Зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэл	
Тайлангаар 6 677 425	Баримтаар 6 228 625

Тайлбар: 2006 оны БОЭТ-ийн санхүүгийн тайлан дээр зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэлийг 6677425 төгрөг гэж гаргасан байсан ба баримтаар үзэхэд 6228625 төгрөг зөөлөн эдлэл нормын хувцасны зардалд бодитоор зарцуулагдсан бөгөөд үлдсэн 448800 төгрөг нь доорх өөр зүйлд зарцуулагдсан байна.

Зөөлөн эдлэл нормын хувцасны зардал	Зөөлөн эдлэл нормын хувцасны зардал доторх өөр зүйл авсан зардлууд	Тайлангаар гаргасан гүйцэтгэл
	Угаалгын машин	300 000
	Сарнай хивс	101 000
	Ширээний хулдаас	9 600
	Ширээний бүтээлэг	18 200
	Хөшиг	20 000
6 228 625	448 800	6 677 425

2006 оны БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэл

2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн төсөл	2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв	Зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэл	
		Тайлангаар	Баримтаар
9 343 500	11 717 500	6 677 425	6 228 625

Тайлбар: Төлөвлөснөөс нь 2 сая гаруй төгрөгний илүү төсөв батлагдан орж ирж бодит байдал дээр 6,6 сая гаруй төгрөгний төсөв зарцуулагдаж, 5 сая гаруй төгрөгний төсөв илүү гарсан байна.

2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсөвтөө эмч ажилчдынхаа халад, ажлын хувцас болон эмнэлгийн цагаан хэрэглэлийн 1 ээлжийг шинэчлэнэ, мөн хөнжил гудас, ариун цэвэр үйлчилгээний зардлыг нэмж тусган доорх байдлаа төсөвлөсөн байна.

2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийг төсөвлөсөн нь :

	2006 он		2007 оны төсөл
	2005 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө ХБГ	
Нормын хувцас зөөлөн эдлэл			
Нийт ажиллагсад	255	271	260
Нэг ажлын хувцасны үнэ		16500	18000
Нормын хувцас авах зардал		4 471 500	4 680 000
Орны тоо	215	215	215
Цагаан хэрэглэлийн үнэ	8500	8500	8500
Цагаан хэрэглэл авах зардал		1 872 500	1 827 500
Хөнжил гудас авах зардал		3 000 000	3 000 000
Ариун цэвэр үйлчилгээний зардал		2 500 000	3 500 000
Нийт зардалын үнэ		11 799 000	13 007 500
Материал нөөцийн үлдэгдэл		0	0
Тухайн жилд төлөвлөсөн зардал	6789900	11 717 500	13 007 500

2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв

Зардлын ангилал	Батлагдсан төсөв
Зөөлөн эдлэл нормын хувцас	8 000 000

Тайлбар: Гэтэл зөөлөн эдлэл нормын хувцасанд 8сая төгрөг батлагдаж орсон байна.

2007 оны БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн төсөл ба батлагдсан төсвийн харьцуулалт

2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн төсөл	2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв	Төсвийн төсөл болон батлагдсан төсвийн зөрүү	
		Тоогоор	Хувиар
13 007 500	8 000 000	5 007 500	38.4% дутуу

Зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэл

Зардлын ангилал	Төсвийн гүйцэтгэл /тайлангаар/
Зөөлөн эдлэл нормын хувцас	8 000 000

Тайлбар: 2007 оны санхүүгийн тайлангаас харахад 8 сая төгрөг л зөөлөн эдлэл нормын хувцсыг авахад зарцуулагдсан байна.

2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт

2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв 2007	2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэлийн зөрүү	
		Тоогоор	Хувиар
8 000 000	8 000 000	0	

Тайлбар: Тайлан дээрх 2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэлээр харахад орж ирсэн төсөв бүрэн зарцуулагдсан харагдаж байгаа юм.

Тайлан дээрх гүйцэтгэл болон баримт дээрх гүйцэтгэл:

Зөөлөн эдлэл нормын хувцасн төсвийн гүйцэтгэл	
Тайлангаар 8 000 000	Баримтаар 8 385 14

2007 оны БОЭТ-ийн зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэл

2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн төсөл	2007 оны зөөлөн эдлэл нормын хувцасны батлагдсан төсөв	Зөөлөн эдлэл нормын хувцасны төсвийн гүйцэтгэл	
		Тайлангаар	Баримтаар
13 007 500	8 000 000	8 000 000	8 385 140

Тайлбар: 2007 онд зөөлөн эдлэл нормын хувцсанд орж ирсэн төсөв бүрэн зарцуулагдсан гэж тайланд тусгагдсан боловч бодит байдал дээр баримтыг үзэхэд зөөлөн эдлэл нормын хувцасны зардал 385140 төгрөгөөр хэтэрсэн бөгөөд түүний 275850 төгрөгийг нь түлш халаалтны зардлаас, 109290 төгрөгийн зардлыг хоолны зардлаас гаргасан байна.

ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ НОРМЫН ХУВЦАСНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ

БОЭТ-ийн 2006, 2007 оны зөөлөн эдлэл нормын хувцаст багтах эмнэлгийн ажилчдын халад, ор хөнжлийн даавуу, гудас хөнжлийн нийлүүлэлтийн байдлыг харахад 85-90 % ийг нь хотын компаниудаас захиалан- нийлүүлж байна

2006 оны зөөлөн эдлэл нормын хувцасны нийлүүлэлтийн байдал

Зөөлөн эдлэл нормын хувцсыг нийлүүлдэг байгууллага, хувь хүмүүс	Хаана	Нийлүүлсэн зөөлөн эдлэл нормын хувцасны төрөл	Зөөлөн эдлэл нормын хувцасны тоо ширхэг	Зөөлөн эдлэл нормын хувцасны нэг бүрийн үнэ	Нийт мөнгөн дүн
Их-Уул ХХК	УБ	Өмд цамц малгай	121 ширхэг	14375	5671225
		Өмд малгай	95 ширхэг	14375	
		Хагалгааны халад	55 ширхэг	18400	
		Хагалгааны бүтээлэг 150*200	20 ширхэг	11500	
		Хагалгааны бүтээлэг 180*100	20 ширхэг	14950	
		Ажлын өмд цамц	8 ширхэг	20700	
		Халад малгай	35 ширхэг	14375	
		Өмд цамц малгай	20 ширхэг	14375	
		Өмд цамц малгай	4 ширхэг	17250	
		Нярайн даавуу Зузаан Нимгэн	97 ширхэг 2 ширхэг	1000 700	
Дөл ХХК	УБ	Нярайн даавуу	100 ширхэг	700	98 400
Дөрвөн-Марал ХХК	ӨВ	Нярайн даавуу	100 ширхэг	700	70 000
Цэцэн харцага	ӨВ	Эмчийн халад	1 ширхэг	11000	11000
Баяннайман ХХК	ӨВ	Одъяал /хүүхдийн хөнжил /	5 ширхэг	8 000	40 000
Насантогтох	ӨВ	Мэс заслын даавуу :			338 000
		Даавуу 250*156	10 ширхэг	9375	
		Даавуу 180*156	1 ширхэг	6750	
		Даавуу 180*90	10 ширхэг	5250	
		Даавуу 180*110	10 ширхэг	8250	
		Нүхтэй даавуу 220*156	10 ширхэг	8250	
Даавуу 113*180	10 ширхэг	4500			
Нийт дүн					6 228 625